



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалт, Хөвсгөл аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 23-07-628/158 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 22 нэрийн, нийт 15,204,606.27 (арван таван сая хоёр зуун дөрвөн мянга зургаан зуун зургаан төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 14,369,069.35 (арван дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга жаран есөн төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөвсгөл аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Я.Эрхэмбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, барилга байгууламжийг буулгаж цэвэрлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан барилгын доорх газрыг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээн, нөхөн сэргээх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123007585
1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2 дүгээр сарын 12-ны/ний өдрийн
1 дүгээр хуулийн дугаар тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Зуны сууц	1986 /2018.12.31-нд дахин үнэлж, шилжүүлэн авсан/	1	367,718.44	367,718.44	312,560.64	55,157.80
2	Агуулах	1954 /2018.12.31-нд дахин үнэлж, шилжүүлэн авсан/	1	162,864.59	162,864.59	162,864.59	-
3	Агуулах	1954 /2018.12.31-нд дахин үнэлж, шилжүүлэн авсан/	1	317,335.16	317,335.16	227,423.61	89,911.55
4	Граж	1984 /2018.12.31-нд дахин үнэлж, шилжүүлэн авсан/	1	4,603,117.19	4,603,117.19	3,912,649.62	690,467.57
5	Компьютер Делл	2007.12.26	1	736,470.00	736,470.00	736,470.00	-
6	Телевизор	2008.07.07	1	170,000.00	170,000.00	170,000.00	-
7	Тог баригч	2017.12.31	2	125,290.00	250,580.00	250,580.00	-
8	Notebook Acer Aspire v3-571	2013.10.28	1	1,099,000.00	1,099,000.00	1,099,000.00	-
9	Dell Dimension E-520 дэлгэц	2006.12.28	1	1,236,682.00	1,236,682.00	1,236,682.00	-
10	Гүйлтийн зам	2008.07.04	1	420,000.00	420,000.00	420,000.00	-
11	Notebook Dell 4110	2011.12.19	1	943,500.00	943,500.00	943,500.00	-
12	Канон IR2018N	2015.01.20	1	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	-
13	Canon IR 2016 J хувилагч	2007.12.29	1	1,771,884.67	1,771,884.67	1,771,884.67	-
14	Ямахо мотор	2007.12.31	1	300,000.00	300,000.00	300,000.00	-
15	Стол	2003.06.28	1	30,000.00	30,000.00	30,000.00	-
16	Шилэн ширээ компьютер	2006.01.07	1	63,270.00	63,270.00	63,270.00	-
17	Туслах ширээ	2003.06.28	1	104,000.00	104,000.00	104,000.00	-
18	Биллярдын ширээ	2006.12.31	1	300,000.00	300,000.00	300,000.00	-

19	Хивс		2006.06.30	1	280,000.00	280,000.00	280,000.00	-
20	Сандал тортой хар		2019.12.31	5	180,000.00	900,000.00	900,000.00	-
21	Сандал МИД		2010.10.26	2	26,342.11	52,684.22	52,684.22	-
22	Сингапур сандал		2006.06.30	1	95,500.00	95,500.00	95,500.00	-
НИЙТ ДҮН				28	14,332,974.16	15,204,606.27	14,369,069.35	835,536.92
						(арван таван сая хоёр зуун дөрвөн мянга зургаан тегрэг хорин долоон мөнгө)	(арван дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга жаран есөн тегрэг гучин таван мөнгө)	(найман зуун гучин таван мянга таван зуун гучин зургаан тегрэг ерэн хоёр мөнгө)